

**ЗХУ, БНМАУ ДАХЬ ОЛЗЛОГДСОН ЯПОН
ЦЭРГҮҮДИЙН АСУУДАЛ
(1945-1956)**

Б.ЭРДЭНЭБИЛЭГ

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд Дэлхийн II дайны төгсгөлийн үед Ази дахь дайны ялагдагч улс болох Японы армиас ялагч гүрэн ЗХУ-д олзлогдсон хүн хүчний хохирлын тухай асуудалд анхаарлаа хандуулсан болно. Японы эсрэг хийсэн чөлөөлөх дайны үед Зөвлөлтийн талд нийт 640 мянга гаруй цэрэг, дарга олзлогдсоноос 609 мянга нь япон үндэстэн, 30 мянга орчим нь бусад үндэстэн байжээ. Үүнээс БНМАУ-ын талд 12318 олзны япон цэргүүдийг 1945 оны 11 дүгээр сард хүлээлгэн өгчээ. ЗХУ болон БНМАУ-ын нутагт олзлогдон ажиллаж байсан япон цэргүүдийн бодит хохирлыг тооцон үзэхэд ЗХУ-ын нутагт олзлогдсон япон 609.448 хүнээс 61.855 хүн буюу 10.14% нь нас барсан бол БНМАУ-ын нутагт байсан япон 12318 хүнээс 1612 хүн буюу 13.08% нь нас барсан байна.

Түлхүүр үг: дайн, ялалт, арми, ялагдал, олзолт

Ази-Номхон далайн бүс нутаг дахь дайн бол Дэлхийн II дайны салшгүй нэг хэсэг юм. Түүнийг Япон улс 1941 оны 12дугаар сарын 7-ны өдөр эхлүүлсэн бөгөөд түүнд нэг талаас Япон, нөгөө талаас АНУ, Их Британи, Голланд, Хятад дайтаж, хэн нь Зүүн, Зүүн Өмнөд Азид болон Номхон далайд ноёрхохын төлөөх дайн байлаа.

Түрэмгийллийг Япон эхлүүлэхдээ өөрийн аж үйлдвэрийн хүчин чадал, цэрэг-эдийн засгийн чадавх, мөн эзлэн аваад байсан Манжуур, Хятад болон Солонгосын хүчийг шавхах зэрэгт найдлага тавьж байв. 1941 он гэхэд японы арми 2 сая 410 мянганцэрэг (130 дивиз, бригад), 3200 цэргийн нисэх онгоц, 10 шугаман /их хэмжээний хүн хүч, зэвсэг тээвэрлэх хүчин чадал бүхий/ хөлөг онгоц, 10 онгоц тээгч, 37 крейсер онгоц, 110 сөнөөгч, 63 усан доогуур шумбагч онгоцтой байв. Японы хуурай замын цэрэг нь 5 орчим хүний бүрэлдэхүүнтэй байсан бөгөөд Өвөр Монгол, Манжуур, Зүүн хойд Хятад, Солонгост байрлаж байсан Квантуны

армийн бүрэлдэхүүнд 1,5 сая цэрэг багтаж байжээ.¹

Японы санаархал бол Ази, Номхон далайд ноёрхлоо тогтоох явдал байлаа. Чингэхдээ Номхон далай дахь АНУ-ын гол бааз болох Сувдан эрэг (Pearl Harbor)-г цохилт өгч, эзлэн авах явдал байв. Япончууд 1941 оны 12 дугаар сарын 7-ны өглөө америкийн бааз руу гэнэтийн довтолгоон хийж, үлэмжхэн хохирол үзүүлсэн аж. Энэ хэрэг явдлаар эхлүүлэн япончууд Номхон далайн Азийн хэсэгт болон улмаар Ази тивийн эх газарт дайны үйл ажиллагаа явуулж, дэлхийн дайныг өдөөгч Германы холбоотон болсон юм.

Эл үед Номхон далайд АНУ болон Их Британи нь 14 шугаман онгоц, 220 онгоц бүхий 3 онгоц тээгч, 39 крейсер онгоц, 114 зөөгч болон 70 шумбагч онгоц мөн Ази дахь тэдний холбоотон болох Австрали, Голланд болон Хятад (Чан-Кайши)-ын 360 мянган цэрэг бүхий 22 дивиз, 1329 цэргийн нисэх онгоцтой байсан бөгөөд дайны явцад нилээд хэмжээний хүчийг нэмэн илгээж байсан холбоотон гүрнүүдийн хамтарсан хүчний довтолгоон 1943 оны 5 дугаар сараас эхлэн идэвхжиж, 1944 он гэхэд тус бүс нутаг байлдааны ажиллагааны санаачлага тэдний гарт бүрэн шилжжээ. Үүнд нөлөөлсөн нэгэн хүчин зүйл бол тус бүс нутгийн ард түмнүүдийн үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний өрнөлт байв.

1945 он болж ирэхэд дайны ажиллагаа Японы арлын эрэгт дөхөж, Филиппины арлууд, Бирм, Индонезийг чөлөөлсөн байв. Америкчууд Иводзимо, Окинава арлуудыг эзлэн авч бусадарлуудад байрлах стратегийн объектуудыг нь бөмбөгдөх болов. Гэвч Япон мөн л хүчирхэг байжээ. Ази, Номхон далай дахь дайны үйл ажиллагааны ачааллаараа Европын хэмжээнд арай хүрэхгүй ч гэсэн асар том орон зайд 45 сар байлдааны үйл ажиллагаа явагдаж, холбоотнууд далай тэнгисийн 20 тулалдаан, 50 орчим усан цэргийн десантын операц явуулжээ.

Дэлхийн II дайны төгсгөлийн үед

Хүн төрөлхтнийг Германы фашизм, Японы милитаризмын түрэмгийллээс чөлөөлөх дайныг Холбоотон гүрнүүд хамтын хүчээр Дэлхийн II дайны явцад хэрэгжүүлсэн билээ. Холбоотон гүрнүүдийг тэргүүнүүд удаа дараагийн уулзалтаараа энэхүү хөнөөлт дайныг хэрхэн төгсгөх талаар хэлэлцэн тохиролцож, Европт дайн дууссаны дараа Ази, Номхон далайн дайралтыг хийхээр эвслийнхний хоёр дахь уулзалт болох 1945 оны 2 дугаар сарын 11-нд Крымийн Ялта² дахь

¹ https://mn.wikipedia.org/wiki/квантуны_арми

² Ялта-Украйн улсын Хар далайн эрэг дэх Крымийн хойгийн хот

Ливадын цагаан ордонд¹ хэлэлцэн тохирсон юм. Ингээд тэрхүү тохиролцоог сийрүүлвээс:

“Турван их гүрэн: ЗХУ, АНУ болон Их Британи удирдагчид хэлэлцэн тохиролцсон нь: Герман үг дуугүй буун өгч, Европт дайн дууссанаас хойш 2-3 сарын дараа ЗХУ холбоотны талд орж, Японы эсрэг дайнд дор дурдсан болзолтойгоор орно. Үүнд:

1. Гадаад Монголын (БНМАУ) Статус-квог /одоогийн байгаа байдал/ хадгалах.
2. 1904 онд Япон итгэл эвдэн довтолсноор эвдэгдсэн Оросын эрхийг сэргээх, үүнд:
 - а. Сахалины арлын өмнөд хэсэг болон түүний зэргэлдээ бүх арлыг ЗХУ-д буцаан өгөх
 - б. Худалдааны Дайрэн² боомтыг олон улсынх болгох. Тэгэхдээ энэ боомтод голчлон ЗХУ-ын сонирхлыг хангах, Порт Артур нь ЗСБНХУ-ын тэнгисийн цэргийн боомт мөний хувьд түрээс төлөх явдлыг сэргээх.
 - в. Зөвлөлт-Хятадын хамтарсан нийгэмлэг байгуулан, голчлон ЗХУ-ын сонирхлыг хангах үүднээс Дорнод Хятадын төмөр зам болон Дайрэн руу орсон Өмнөд Манжуурын төмөр замыг хамтран ашиглах, тэгэхдээ Хятадын Манжуур дахь бүрэн эрхийг хэвээр үлдээнэ.
3. ЗХУ-д Курилын арлуудыг шилжүүлэн өгөх³ зэрэг болно.

ЗХУ нь Ази тив дэх дайныг дуусгавар болгох ажиллагаанд оролцсоноор 1904-1905 оны Орос-Японы дайны ялагдлаар Японд алдсан зүйлээ эргүүлэн авахыг хүсчээ. Нөгөө талаар Зөвлөлт өөрийн Алс Дорнодын хил хязгаарынхаа аюулгүй байдлыг хангах асуудал амин чухал зүйл нь байв.

Эцэст нь Холбоотон гүрнүүдийн өмнө өгсөн амлалтаа биелүүлэх үүднээс 1945 оны 8 дугаар сарын 9-ний шөнө ЗХУ Японы эсрэг дайнаа эхлүүлсэн нь Дэлхийн II дайны үргэлжлэл байсан бөгөөд оросын түүх бичлэгт үүнийг “Аугаа их эх орны дайны логик үргэлжлэл” хэмээн үздэг.

Дорно зүгт илт түрэмгий бодлого баримталж байсан Япон өөрсдийгөө ялагдаж буй (хэдүйвээр Европт түүний холбоотон Герман ялагдал хүлээсэн

¹ Ливадий ордонд 1913 онд Монгол улсын ерөнхий сайд Сайн ноён хан Т. Намнансүрэн тэргүүтэй төлөөлөгчид Хаант Оросын эзэн хаан II Николай хаантай уулзаж байсан

² Далянь -Дальний-Алсын, эртний хятадаар 大連, хураангуй 大连, пиньинь: Dàlián; японоор 大連, Дайрэн)

³ Советская дипломатия в годы Великой Отечественной войны (1941—1945 гг.) Гл. 12. // А. В. Шатаев. Незагадочный Иосиф Сталин. Кн. 4. — Барнаул: 2010, 55

байсан ч Б.Э.) орон хэмээн тооцохгүй байв. Түүний гол хүч Хятадын баруун хойт хэсэгт орших Манжуурт байв. Армийнхаа хангалтыг Хятад болон Солонгосоос хийж байжээ. 1945 оны зун гэхэд Японы тал Манжуурт 17 бэхлэлт бүхий бүс, 40 орчим нислэгийн талбай барьж байгуулсан байв. Квантуны арми 1,2 сая цэрэг, 1,2 мянган танк, 1,9 мянган байлдааны нисэх онгоц, 6,6 мянган их буу, миномёт бүхий үлэмжхэн хүчийг төвлөрүүлсэн аж.

Зөвлөлтийн тал Чөлөөлөх дайны эхэнд Алс Дорнодод 1,6 сая цэрэг, 20,6 мянган их буу, 5,5 мянган танк, 3,4 мянган байлдааны нисэх онгоц бүхий хүчийг төвлөрүүлж, Ерөнхий командлал байгуулж, түүнийг маршал А.Василевский удирдах болжээ.

8 дугаар сарын 8-ны өдөр Москвад Зөвлөлтийн Засгийн газар Японы элчин сайдад Мэдэгдэх хуудас гардуулсан бөгөөд түүнд, Япон нь АНУ, Их Британи болон Хятадын эсрэг хийж буй дайны үйл ажиллагаагаа зогсоохгүй байгаа учир 1945 оны 8 дугаар сарын 9-ний өдөр дайн зарлаж байна гэдгээ мэдэгджээ. Үүний өмнө ЗХУ-ын Засгийн газар 1945 оны 4 дүгээр сарын 5-нд Зөвлөлт-Японы төвийг сахих гэрээг нэг талаас цуцалсан байв.

Монголын арми чөлөөлөх дайнд оролцсон нь

БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчид, Ардын Сайд нарын Зөвлөлийн / АСнЗ/ гишүүдийн 1945 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн хамтарсан онц хурлаас БНМАУ-аас Японд дайн зарлах тухай тунхаглалыг баталжээ. Энэ нь ЗХУ-тай холбоотон улсынхаа үүргийг биелүүлсэн явдал байлаа.

Монгол ардын хувьсгалт цэрэг нь оперативын удирдлагын хувьд Зөвлөлтийн армийн Өвөр Байгалийн фронтын бүрэлдэхүүнд багтаж, дэслэгч генерал И.А.Плиевийн удирдлагын дор зөвлөлтийн нэгтгэл, ангиудын хамтаар “Өмнөд бүлэг” хэмээх морьт механикжуулсан группыг бүрэлдүүлжээ. Тус группт МАХЦ-ийн 5,6,7,8 дугаар морьт дивиз, морьт тусгай хороод, 7-р механикжуулсан хуягт бригад, танк, их буу, авто тээврийн болон холбооны тусгай хороо, нисэх холимог дивиз, химийн инженерийн тусгай салбар зэрэг гол анги нэгтгэл, хилийн цэргийн отряд, застав, Ардын өөрийгөө хамгаалах сайн дурын морьт отрядын ангиуд оролцжээ. Тус группэд бүгд 42 мянган цэрэг, офицер, 28 мянган морьт, 403 танк, хуягт машин, 610 их буу, миномёт, пуужинт их буу багтаж байв.¹ Эдгээр хүчнээс нийтдээ 16000 гаруй дарга, цэрэг 1945 оны 8 дугаар сарын 10-наас эхлэн Зөвлөлтийн цэрэгтэй мөр зэрэгцэн тулалдаж, 900 гаруй км замыг туулж, Зүүн хойд

¹ *Монгол Улсын түүх*. Боть V. Улаанбаатар: 2003, 299

Хятад, Өвөрмонголын нутаг болон тус бүс нутгийн томоохон хотууд Долоннуур, Жэхэ, Чуулалт хаалгыг Квантуны армиас чөлөөлөхөд оролцжээ.

Мөн МАХЦ-ийн дайчид болон чөлөөлөгдсөн нутгийн ард олонд үйлчлэх зорилготой Цэргийн эмнэлэг, Цэргийн ансамбль, ухуулга сурталчилгааны бүлгүүд чөлөөлөгдсөн нутгуудад ажиллаж, Өвөр монголын ард түмэнд хүмүүнлэгийн болон сэтгэл санааны тусламж дэмжлэг үзүүлэх, БНМАУ-ын хөгжилт бэхжилт, ард түмний амьдрал, Монгол, Хятадын ард түмний найрамдлын талаар сурталчлах үүрэг гүйцэтгэжээ.

Монгол, Зөвлөлтийн цэргийн давшилтаар эхэлсэн Ази дахь японы дарангуйллаас чөлөөлөх дайн 1945 оны 9 дүгээр сарын 2-нд Япон улс бууж өгснөөр төгсгөл болов. ЗХУ-ын шийдвэрийн дагуу 1945 оны 9 дүгээр сарын 3-нд БНМАУ-д Ялалтын баярыг өргөн дэлгэр тэмдэглэжээ.

Олзны цэргийн талаарх олон улсын гэрээ хэлцлүүд

Хүн төрөлхтний түүхэн хөгжилд дайн байлдаан, мөргөлдөөн, засгийн эрхийн төлөөх зэвсэгт тэмцэл гэх мэт хүч хэрэглэсэн түүхэн үйл явдлууд олонтоо гарч байжээ. Тийнхүү хүч хэрэглэн маргаантай асуудлыг шийдэх явцад эсрэг талаа жагсаалаас гаргах үүднээс сөрөг талынхныгаа олзлон авах явдал гарах нь нэн түгээмэл аж. Олзлон авах гэдэг нь “эрх чөлөөт байдлаас эрх болон чөлөөт байдлыг нь хязгаарлах байдалд оруулж буй явдлыг нэрлэнэ” гэж судлаачид үздэг.

Түүхнээ цэргийн олзны хүмүүст хамаарах анхны баримт бичгийг 1863 онд Анри Дюнон гэх швейцарь хүний санаачлагаар буй болжээ. Дараа жил нь Женев хотноо Европын 16 орон оролцсон бага хурал хуралдаж, цэргийн олзлогдогсдын талаархи Гэрээ бичиг (конвенц-Б.Э.) батлан гаргав. Тус гэрээнд Хаант Орос 1864 онд нэгдэн орж, улмаар АНУ-ын хамт 1899 болон 1927 оны энх тайвны бага хурлыг санаачлан хуралдуулж, дайныг явуулах тухай Гэрээний 13 системийг боловсруулан гаргажээ.

Дайныг хэрхэн явуулах тухай анхны дүрмийг Гаага хотноо 1899 онд хуралдсан Энх тайвны хурлаар батлан гаргасан бөгөөд түүн дотор цэргийн олзны асуудлыг хэрхэн шийдэж байх талаар заан өгчээ. Гаагын 1907 оны II хурлаар баталсан шинэ Конвенцээр цэргийн олзны цэргүүдийн эрх зүйн хэм хэмжээг тогтоосон байна. Олзлогдох гэдэг нь Тунхаглалд зааснаар: зөвхөн аюулгүй байдлын үүднээс хоригдлуудын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хэлтрүүлэх үүднээс хорих явдал юм¹ гэжээ.

¹ Международное право в системном изложении / Ф. Лист. – Юрьев/ Москва: 1909, 397

Дэлхийн I дайннь (1914-1918 он) цэргийн олзлолтын хэм хэмжээг цаашид боловсронгуй болгохыг шаардсан юм. Тиймээс 1929 оны 7 дугаар сарын 27-нд Женевийн конвенц 81 зүйл бүхий 7 хэсэгтэйгээр батлагджээ. Түүнд цэргийн хорих газар, олзлон авах нөхцөл зэргийн талаар заан өгч, олзлогдогсдын хөдөлмөрийг ашиглах талаарх заалт орсон байна. Чингэхдээ олзлогдсон эрүүл цэргүүдийн хөдөлмөрийг ашиглахдаа тэдний нийгмийн байдал болон эзэмшсэн мэргэжлийг харгалзан үзэж зохион байгуулна¹ гэжээ. Шинэ дүрэм ёсоор олзны офицерууд болон түүнтэй дүйцэх цолтнууд нь хэрэв өөрсдөө зөвшөөрвөл хөдөлмөр эрхлэх бөгөөд харин бага цолтой офицерүүд (унтер-офицер) жирийн олзны цэргүүдийн хөдөлмөрийн үйл ажиллагааг хянах ажил хийж болох бөгөөд чингэхдээ цалин хөлс авна. Олзны цэрэг нь тухайн орон нутгийн хүмүүсийн нэгэн адил ажлын цагтай байх ёстой бөгөөд илүү цагаар ажиллуулахыг хориглоно. Долоо хоногт 24 цагийн амралт эдлүүлнэ.

Хориглох зүйлүүдэд: Олзны цэргийн хөдөлмөр нь армийн хэрэгцээнд зориулсан ямар нэгэн зүйлийн тээвэрлэлт хийлгэх, зэр зэвсэг үйлдвэрлэх болон тээвэрлэх, цэрэг дайны зориулалттай барилга барих зэрэгт ашиглагдах ёсгүй. Ямар ч олзны цэрэг өөрт нь эрүүл мэндийн хувьд тохирохгүй болон эрүүл мэндэд нь муугаар нөлөөлөх хөдөлмөр эрхлэх ёсгүй.

Дээрхи конвенцийн дараа мөнхүү 1929 онд өөр хоёр шинэ гэрээ байгуулагдсан байдаг. Энэ нь

“Цэргийн олзлогдогсодтой харьцах тухай” болон “Арми дахь шархадсан болон өвчтэй цэргүүдийн байдлыг сайжруулах тухай” зэрэг байв. Ингээд гэрээнд нэгдэн Европын улс түмнүүд конвенцийн заалтуудыг биелүүлж байжээ. Япон улс 1929 онд тус конвенцид нэгдэн орсон байна.

БНМАУ-ын холбоотон болох ЗХУ 1939 оны 3 дугаар сарын 19-нд өөрийн дүрмийг тогтоож, дээрхи Женевийн “Цэргийн олзлогдогсодтой харьцах тухай” конвенцийн заалтуудаас арай өөр журмыг тогтоосон байна. Тухайлбал, Зөвлөлтийн тал өрнөдийнхний “дайтагч гүрнүүд боломжийнхээ хирээр хорих газарт нэгэн үндэстэн, ястанг хорих явдлаас зайлсхийх ёстой”² гэсэн зүйл нь үндэсний болон арьс өнгөөр ялгарлах явдлыг хуульчилж байна хэмээн үзэж байгаа учир түүнийг дагахгүй гээд өөрийн “ЦИК и СНК СССР Постановлением № 46”³ гэдгийг батлан гаргаж мөрдөх болжээ.

¹ Военнопленные в СССР. 1939-1956. Документы и материалы. Москва: 2000, 1017

² Кузнецов, С.И. *Японцы в сибирском плену (1945-1956 гг.)*. Иркутск: 1997, 29

³ *Военнопленные в СССР. 1939-1956. Документы и материалы*. Москва: 2000, 25

Дэлхийн II дайн эхэлсний дараа 1941 оны 7 дугаар сарын 1-нд Зөвлөлтийн Ардын Комиссариат Цэргийн олзлогдогсдийн талаархи 1939 оны шийдвэрээ эргэн харж, найруулан бичихдээ: дайнд олзлогдогч гэдэг нь: а) ЗХУ-тай дайны байдалд байгаа орны зэвсэгт хүчинд хамаарч, дайны ажиллагааны үед баривчлагдсан хүмүүс болон Зөвлөлтийн газар нутаг дээрх тусгаарлагдсан тэдгээр орнуудын иргэд, б) дайсны зэвсэгт хүчинд үл хамаарах боловч зэвсэглэсэн бүлэгт хамааран илт зэвсэгтэй явж буй этгээд, в) цэргийн үйл ажиллагааны явцад олзлогдсон сурвалжлагчид, ханган нийлүүлэгч, цэргийн хамт зөвшөөрөл бүхий бусад хүмүүс болон дайсны хөлөг онгоцыг дагалдан яваа энгийн иргэд зэрэг болно¹ гэжээ.

Дээр дурдагдсан “таслагдсан” буюу “интернированный” гэх хүмүүсийн асуудал Гаагийн (1899 и 1907 гг.) болон 1949 оны Женевийн IV конвенцийн “Дайны үед энгийн хүн амыг хамгаалах тухай” гэрээнд буй.

Ингээд энэхүү 1941 оны Зөвлөлтийн журмын дагуу Алс Дорнод дахь Чөлөөлөх дайны үед (1945.8-1945.9) олзлогдсон япон цэргүүд ЗХУ болон БНМАУ-ын газар нутаг дээр байршиж байсан байна.

Дэлхийн II дайны дараа 1949 оны 8 дугаар сарын 12-нд Женевийн III конвенцоор баталсан “Дайны олзлогдогчидтой харьцах тухай” гэрээнд дэлхийн 166 орон нэгдэн орсон бөгөөд БНМАУ 1958 онд албан ёсоор нэгдэн орсон юм. Дэлхийн II дайны цэргийн олзлогдогсдын тоо 35 сая хүн² байсан гэдэг.

Чөлөөлөх дайны олзны цэргүүдийн асуудлыг нэхэн эргэцүүлэхүй

ЗХУ дахь олзны япончуудын асуудал. 1945 оны 5 дугаар сард Европ тивд Германы фашизм болон түүний холбоотнуудыг бут ниргэж чадсан боловч Ази, Номхон далайн бүс нутагт Японы түрэмгийлэл хэвээр үргэлжилж байв. Хэдүйбээр АНУ, Их Британи болон Хятадтай холбоотон болон тус бүс нутагт дайны ажиллагаа явуулж байсан боловч Квантуны арми хүчирхэг байв. Тиймээс ЗХУ холбоотон их гүрнүүдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж чөлөөлөх дайныг эхлүүлсэн билээ. Энэ дайн мөн л ихээхэн хөнөөлт дайн байв. Энэ нь зөвхөн үхэл, сүйрлийг авчирсан төдийгүй олон сая хүний амь нас, эрүүл мэнд, сэтгэл санааны дарамтны асуудал байв.

Дайны жилүүдэд ЗХУ-д ялагдагч орнуудаас 4,126,964 хүн олзлогджээ³. Янз бүрийн байдлаар олзонд орсон цэргийн албан хаагчийн хувь тавилан нэн хүнд,

¹ *Военнопленные в СССР. 1939-1956*, 66

² Галицкий, В.П. Проблема военнопленных и отношение к ней Советского государства”, *Советское государство и право*. 1990, № 4, 124

³ *Военно-исторический журнал*. 1990, № 9, т. 45

тэднийг эх орноосоо урвагч хэмээн тооцож, тэдний үр хойчис ч жаргал үзээгүй мэт.

Японы эсрэг хийсэн чөлөөлөх дайны үед нийт 640.105 хүн олзлогдсоны бага тушаалын дарга, цэрэг, энгийн япон хүн 609.448, командалалын дээд алба тушаалтан 260 байжээ. Эдгээрийн 62,069 нь 1945-1956 оны хооронд Зөвлөлтийн нутаг дээр нас баржээ¹.

Ази Номхон далай дахь хүн хүчний алдагдлыг оросуудын хийсэн хүснэгтээс харвал² дайны үйл ажиллагаа явагдсан нутгийнхан нилээд хохирол амсчээ. Үүнд

Үндэстэн	Олзлогдсон	Эх оронд нь буцаасан	Нас барсан
япон	609 448	546 752	61 855
хятад	16 150	16 012	138
солонгос	10 312	10 240	71
монгол	3 633	3 629	4
манж	486	486	-
орос	58	58	-
малай	11	11	-
буряд	5	4	1
тунгус	2	2	-
нийт	640 105	577 194	62 069

Зөвлөлтөд олзлогдсон япон цэргүүдийн асуудлыг шийдэх явц 1956 он хүртэл үргэлжилжээ. Эл хэрэгт нөлөөлсөн нэгэн чухал үйл явдал бол 1955 онд 7 дугаар сарын 1-нд Лондонд Их Британи дахь Зөвлөлтийн элчин сайд Я.И.Маликаар толгойлуулсан Зөвлөлтийн төлөөлөгчид Японы элчин сайд Мацумото Сюнъитигээр ахлуулсан Японы төлөөлөгчидтэй уулзаж, хэлэлцэний дараахан 1956 оны 10 дугаар сарын 19-нд тус хоёр орны хооронд дипломат болон консулын харилцааг сэргээх тухай Тунхаглалд гарын үсэг зурсан явдал байв. Тунхаглал 1956 оны 12 дугаар сарын 12-нд хүчин төгөлдөр болж, ЗХУ-ын Дээд Зөвлөлийн зарлиг гарч, тус оронд шийтгэгдсэн японы иргэдэд өршөөл үзүүлжээ. Ингээд 12 дугаар сарын 24-ний өдөр Зөвлөлтийн Находка боомтоос “Коан Мару” хөлөг онгоцоор 1945 оны дайны үед олзлогдсон япончууд эх орондоо харьжээ. Гэвч үүгээр асуудал дуусаагүй юм. Япончуудын тооцоогоор цаана нь 10 мянган япончууд ор сураггүй алга болсон гэсэн бүртгэл байдаг. Зөвлөлтийн тал тэднийд нас барсан олон япончуудыг шарилыг эх оронд нь өгөх ажил хийсэн аж.

1991 онд ЗХУ-ын ерөнхийлөгч М.С.Горбачев Японд айлчлах үедээ Зөвлөлтөд нас барсан японы олзлогсдийн нэрсийн зарим жагсаалтыг өгч, тэднийг нас барсанд эмгэнэж байгаагаа илэрхийлжээ. 1993 онд Оросын ерөнхийлөгч Б.Н.

¹ Карасев, С.В. *История плена: советско-японская война и ее последствия* :1945 - 1956 годы.

² *Большая Отечественная без грифа секретности*. Книга потерь. Изд-во Вече, 2014, 337

Ельцин Сталины дэглэмийн үед японы цэргийн олзлогдогсдийн хувьд явуулж байсан шудрага бус бодлогын золиос болж, тус орны хорих газруудад нас барсан япончуудад харамсал илэрхийлж, уйчлал гуйжээ. ОХУ 1992 оноос эхлэн хуучин ЗХУ-ын олон улсын өрийг төлөх явцдаа тэдний оронд олзонд байсан японы цэрэг болон офицеруудын хөдөлмөр эрхлэлтийн талаар тодорхойлолт гарган өгч эхлэсэн бөгөөд 1993 онд ОХУ-ын Архив Гадаад яамтайгаа хамтран 30 мянган тодорхойлолт японы талд өгчээ¹. 2000 онд япончуудын шарилыг эргүүлэн олгож, Японы тал түүнийг эх оронд нь оршуулах ажиллагааг эхлүүлжээ.

Өдгөө ОХУ-д урд өмнө хаалттай байсан Архивууд нээлттэй болж, оросын судлаачид олзны япончуудын талаархи судалгааг эрчимтэй хийж байгаа билээ.

БНМАУ дахь японы олзны цэргүүд

Дэлхийн II дайны Ази дахь төгсгөлд голлох үүрэгтэй орсон ялагч Зөвлөлтийн тал японы 600 мянга гаруй дарга, цэргүүдийг олзлон авсанаас дайнд ялагч улсуудын тоонд багтсан БНМАУ-ын талд 12 мянга гаруй олзлогдогсдыг 1945 оны сүүлээр хүлээлгэн өгчээ.

Зөвлөлт, Монголын хамтарсан хүчин 1945 оны 8 дугаар сарын 9-нөөс Өвөрмонголын зүүн, баруун хэсгийн хэд хэдэн чиглэлээр цөмрөн орж, японы эзэмшилд буй газар нутгийг чөлөөлөх дайны үйл ажиллагаа явуулжээ. БНМАУ-ын зэвсэгт хүчин бүрэлдэхүүнд нь багтаж байсан Өвөр Байгалийн фронтын “Өмнөд бүлэг” давшилтынхаа гол цохилтыг БНМАУ-ын Тамсагбулагийн районоос Их Хянганы нурууг давж, Чанчунь, Мүгдэнгийн чиглэлээр хийж, фронтын бусад хүчтэй хамтран Квантуны армийг Манжуурын төв хэсэгт бүслэн бут цохих үүрэгтэй байв. Долоннуур-Жэхэгийн чиглэлийн бүрэлдэхүүнд Монголын талаас 5-р морьт дивиз, танкийн 3-р хороо, холбооны тусгай хороо, нисэх холимог дивиз, мөн 11, 12-р тусгай морьт хороо зэрэг анги нэгтгэл багтаж байв. Монгол-Зөвлөлтийн морьт механикжуулсан групп өмнөө тавьсан үүргээ амжилттай биелүүлж, 8 дугаар сарын 13-нд Долнуурыг, 19-нд Жэхэг, 21-нд Чуулалт хаалгыг эзэлжээ. Жэхэд байсан Японы цэргийн гарнизон Монгол-Зөвлөлтийн группийн командлалд зэвсгээ хураалган бууж өгч, Япон-Манжго-гийн 8000 гаруй цэрэг, офицер олзлогджээ.²

Японы олзлогдсон цэргүүдийг 1945 оны 11 дүгээр сарын 20-ноос эхлэн 20 хоногийн хугацаанд 12318 олзлогдогсдыг нэрсийн жагсаалтгүйгээр тоолон авч,

¹ “Известия” сонин, 1993 оны 4 сарын 13

² *Монгол Улсын түүх*. Боть V. Улаанбаатар: 2003, 301

6 удаагийн цуваагаар Монголд авчирсаны¹ дотор ахлах офицер 15, дунд офицер 678, бага дарга 2178, цэрэг 8079, энгийн япон албан хаагчид 1368 байжээ².

Олзлогдогсдыг хүлээн авах бэлтгэл ажилтай холбогдуулан БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн /СнЗ/ 1945 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 61 дүгээр хурлын шийдвэрээр Дотоод Явдлын яаманд /ДЯЯ/ Олзлогдсон цэргүүдийн лагериудыг удирдах хэлтсийг байгуулж, удалгүй газар болгон өргөтгөж, мөн оны 10 дугаар сарын 4-ний өдрийн 72/59 дүгээр тогтоолоор Олзлогдсон Цэргийн Хэргийг Эрхлэх Ерөнхий газрыг /ОЦХЭЕГ/ байгуулж, ерөнхий газрын даргаар намын ажилтан байсан Сосорбарамд хошууч генерал цол олгож, томилжээ.³

СнЗ-ийн 1945 оны 10 дугаар сарын 4-ний өдрийн 72 дугаар хурлаас баталсан “Олзлогдсон цэргүүдэд хэрэглэгдэх идэш уушны зүйлийг тавин олгох тухай” тогтоолд: “Олзлогдсон цэрэг 20 мянган хүнийг хооллоход 3 сар хүрэлцэх хэмжээний хүнсний зүйлүүдийг Дотоод яамны олзлогдсон цэргийн лагериудыг удирдах газарт шилжүүлэн өгөхийг хоршоодын төв холбоо”-нд даалгаснаас үзэхэд 20 мянган олзлогдсон цэрэг хүлээн авахаар бэлтгэл ажлуудыг хийж байжээ. Гэвч 20 мянга биш, 12318 олзлогдогсдыг хүлээн авсан нь хэдий тухайн үед манай улсад барилга, үйлдвэрлэлийн салбарт ажиллах хүн хүч хэрэгцээтэй байсан ч, олон тооны олзлогдсон цэргүүдийг хүлээн авах, байрлуулах, хоол хүнсээр хангах нь эдийн засгийн хувьд хүндрэлтэй байсантай холбоотой гэж үзэж болох юм.

ОЦХЭЕГ-аас 1945 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр Төв Хороо, СнЗ-д явуулсан илтгэх хуудсанд: “Тус газар нь энэ өдөр 5 мянган японыг хүлээн аваад байна. Үүний дотроос тусгай мэргэжлийн хүмүүс 1000 орчим байна”⁴ гэжээ. Дайны дараа Монголын аж ахуй, үйлдвэрлэлийн салбарт тусгай мэргэжлийн хүчин ихэд дутагдалтай байсан бөгөөд дээрх баримтаас үзэхэд, японы олзлогдогсдоос 5 хүн тутмын 1 нь ямар нэгэн тусгай мэргэжилтэй байсныг Монголд авчрахдаа харгалзан үзсэн бололтой.

СнЗ-өөс олзлогдсон япон цэргүүдийг байрлуулах ба ажиллуулах тухай зааврыг батлан гаргаж, японы олзлогдогсдыг хуучин тасаг, салаа, суман, батальоноор нь зохион байгуулж, офицеруудыг хөдөлмөрөөс чөлөөлж, хариуцсан хүмүүсийнхээ хөдөлмөрийг зохион байгуулах, сахилга дэг журмыг сахиулах үүрэгтэй ажиллуулсаны⁵ сацуу ОЦХЭЕГ-ын дэргэд эмнэлгийн хэлтсийг байгуулж, түүний

¹ ТЕГ.Тусгай архив. сан 1, хн 746, т 52

² ТЕГ.Тусгай архив. сан 1, хн 28, т 32

³ ТЕГ.Тусгай архив. сан 1, хн 2, т 5

⁴ ТЕГ.Тусгай архив. сан 1, хн 4, т 1-3

⁵ ТЕГ.Тусгай архив. сан 1, хн 745, т 52

харьяа Сэлбэ, Хужирбуланд япон цэргийн эмнэлэг нээн, лагерь бүрт их, бага эмчийн салбаруудыг байгуулан, урьдчилан сэргийлэх ажлуудыг явуулж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгуудыг 1946, 1947 онуудад хүн бүрт хийжээ.¹

Олзлогдогсдын 90 гаруй хувийг нь Улаанбаатар хотын барилга, барилгын материал үйлдвэрлэлийн ажилд ажиллуулж байсан нь хотжих үйл явц эхэлж байсан нөхцөлд ажиллах хүчнээр хангаж, нийслэл хотын төв хэсгийн өнөөгийн өнгө төрхийг илтгэсэн зарим барилгуудын суурийг тавих ажлыг эхлүүлжээ.

1945 оны 11 дүгээр сарын 2-нд БНМАУ-ын СнЗ, МАХН-ын Төв Хорооны хамтарсан 79/62 дугаар хурлаас баталсан 1945-1946 оны их барилгын төлөвлөгөөнд ОЦХЭЕГ-аас гүйцэтгэх барилгын дотор МУИС-тай холбогдсон 4 барилгыг, тухайлбал, МУИС-ийн оюутны байр, багш нарын байр, мөн сургуулийн хүн, мал эмнэлгийн газар зэрэг дан, давхар барилгыг нэрлэсэн байна.

Олзлогдсон япон цэргүүдийн барьсан барилгуудыг жагсаан үзэхэд:

- Засгийн газрын ордны барилга. /Суурь тавьсан, зарим хэсэгт өрлөг эхэлсэн/
- Монгол Улсын Их сургуулийн хоёрдугаар ээлж. /будгаас бусдыг хийсэн/
- Улсын номын сан./шавардлага, будаг дутуу/
- Гадаад яамны барилга, 23 айлын сууцны хамт /будаг, паркет шал зэргээс бусад/
- “Элдэв-Очир” кино театр /будгийн ажлаас бусдыг/
- Намын сургуулийн хичээлийн байр
- Амбулатори /1 дүгээр төрөх/ өнгөлгөө дутуу.
- Төв театрын барилга. /Суурь тавьж, ханын өрлөг дутуу хийсэн/
- 8 дугаар дэлгүүртэй сууцны барилга барьсан. /дутуу/
- Хотын модон завод, төмрийн тасгийн барилгын их биеийг босгосон.
- Сонгинын амралтын жижиг барилгыг босгосон.
- Махкомбинатын зоорь барьсан.
- Төв бараа баазын агуулах барьсан.
- Хотын тоосгоны заводын нэгдүгээр өргөтгөлийг хийсэн.
- Төв Хорооны 12 айлын сууц зэргийг барьж, тоосго, шохой боловсруулах зэрэг ажилд нэлээд хүмүүс ажиллаж байсан байна.

ЗХУ-аас японы олзлогдогсдыг эх нутагт нь буцаах үйл явц 1946 оны эцсээс эхэлсэнтэй холбогдуулан Монгол дахь олзлогдогсдыг буцаах асуудалд ЗХУ-ын

¹ ТЕГ.Тусгай архив. сан 1, хн 746, т 52

тал ихээхэн анхаарал хандуулах болжээ. Ийм үед японы олзлогдогсдыг Монголд байлгах хугацааг уртасгахыг Монголын талаас ЗХУ-д хүсэлт болгож байжээ.

МАХН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбал 1947 оны 3 дугаар сарын 22-нд Ерөнхий сайд Х.Чойбалсанд Москвагаас илгээсэн цахилгаан утсандаа: “Гадаад яамны орлогч сайд Маликтай уулзаж, манайд байгаа олзлогдсон япончуудыг энэ жилийн дулааны улирлыг дуустал барилга дээр ажиллуулбал бидэнд ихээхэн ашигтай учрыг хэлсэн гэжээ.¹ Үүнээс үзэхэд Зөвлөлтийн тал 1947 оны хавар олзлогдсон япончуудыг буцаах асуудлыг ярьж байсан боловч Монголын тавьсан саналыг харгалзан мөн оны намар хүртэл хойшлуулсан нь тодорхой байна.

Олзлогдсон япон цэргүүдийг 1947 оны 10 дугаар сарын 16-26-ны өдрүүдэд 11 удаагийн цуваагаар буцааж, нийт 10705 хүнийгөвлийн бүрэн хувцастайгаар ЗХУ-ын хил Наушка дээр нэрсийн жагсаалтаар ЗХУ-ын талд хүлээлгэн өгсөн байна. Олзлогдогсдын дотроос үлдсэн хүн байхгүй, харин 1945 оны дайны үед баривчлагдсан 8 хүнээс 2 нь олзлогдогсодтой хамт буцсан, 1 нь шүүхийн тогтоолоор буудагдсан, 1 нь ял эдэлж байх хугацаандаа нас барсан, 4 японыг 1954 оны сүүлийн хагаст БНХАУ-д хүлээлгэн өгчээ. Нийт 13 япон цэрэг манай улсын хуулиар шийтгэгджээ.

Монголд нас барсан япончуудыг нэр бүхий 17 газар оршуулсанаас Дамбадаржаад 835, Хужирбуланд 252, Баруунхараад 58, Угтаалжаргаланд 35, Сүхбаатарт 198, Архустайд 33, Налайх 12, Шохойцагаан булагт 10, Үхэр чулуутад 4, Алтанбулагт 8, Зүүнхараад 44, Ерөөд 96, Батсүмбэрт 2, Зүүнбүрэнд 19, Төв аймгийн Балжид 1, Архангай аймгийн Өгийнуурт 5, Даландавхарт 25, бүгд 1612 шарил байна². Сураггүй алга болсон 1 япон цэргийг нас барагчдын тоонд оруулан тооцдог байна.

Японы олзлогдогсдыг эх нутагт нь буцаасны дараа ОЦХЭЕГ-ыг өөрчлөн байгуулах асуудлаар “Улсын их барилга ба орон нутгийн барилгын үйлдвэрлэлийг ажилчны хүчээр хангах арга хэмжээний тухай” хэмээх БНМАУ-ын СнЗ, МАХН-ын Төв хорооны хамтарсан тогтоолыг 1947 оны 11 дүгээр сарын 4-нд гарган, уг газрыг өөрчлөн СнЗ-ийн дэргэдэх Барилгын хэрэг эрхлэх ерөнхий газар /БХЭЕГ/ болгон яамны эрхтэйгээр байгуулж, ажиллуулахаар шийдвэрлэжээ³.

¹ Дашдаваа, Ч. *Японы олзлогдогсод Монголд*. Улаанбаатар: 2013, 268-269

² ТЕГ.Тусгай архив. сан 1, хн 746, т 63

³ Дашдаваа, Ч. *Японы олзлогдогсод Монголд*. Улаанбаатар: 2013, 274

Дүгнэлт

Дэлхийн II дайны жилүүдэд ЗХУ-д ялагдагч орнуудаас 4 сая гаруй хүн олзлогдсон бөгөөд Японы эсрэг хийсэн чөлөөлөх дайны үед нийт 640.105 хүн олзлогдсоны бага тушаалын дарга, цэрэг, энгийн япон хүн 609.448, бусад үндэстэн /хятад, солонгос, монгол, манж, орос, малай, буриад, тунгус,/ 30657 хүн байжээ.

БНМАУ нь чөлөөлөх дайны ялагч улсын хувиар 1945 оны сүүлээр 12318 олзны япон цэргүүдийг ЗХУ-ын удирдагч нартай харилцан тохиролцсоны үндсэн дээр хүлээн авч, 2 жил орчим цэргийн бус үйлдвэрлэлийн салбар буюу барилга үйлдвэрлэлийн салбарт ажиллуулж байгаад 10705 хүнийг 1947 оны 10 дугаар сард Зөвлөлтийн талд хүлээлгэн өгчээ.

Өдгөө японы зарим судлаачдын зүгээс олзны япон цэргүүдийг олон улсын гэрээний дагуу ажиллуулаагүй гэсэн асуудлыг тавьдаг бөгөөд БНМАУ-ын хувьд олзны цэргүүдийн эрхзүйн хэм, хэмжээг зохицуулсан олон улсын ямар нэгэн гэрээнд элсээгүй байсан /хожим 1958 онд Женевийн конвенцэд элссэн/ бөгөөд 1941 онд ЗХУ-аас гаргасан дайны олзлогдогсдын талаар гаргасан журмын дагуу БНМАУ-д дайны дараа барилга үйлдвэрлэлийн салбарт ажиллах хүчин дутагдалтай байсныг харгалзана олзны япон цэргүүдийг цэргийн бус үйлдвэрлэлийн салбар буюу Улаанбаатар хотын барилга, барилгын материал үйлдвэрлэлийн ажилд ажиллуулж байсан нь хотжих үйл явц эхэлж байсан нөхцөлд ажиллах хүчнээр хангахад чухал үүрэгтэй байжээ.

Монголд ажиллаж байсан япон олзны цэргүүдийн талаарх баримтын судалгааг өргөжүүлэхэд ТЕГ-ын Тусгай архив дахь баримт материал ихээхэн хувь нэмэр оруулах бөгөөд тус архивын материалаас судалгааны эргэлтэнд оруулж байгаа нь уг сэдвийн судалгааг цаашид гүнзгийрүүлэх, бусад архивын баримттай харьцуулан судлах чухал ач холбогдолтой болж байна.

Abstract: This paper focuses on Japanese army's losses prisoners of war in the winner Soviet Union at the end of World War 2. More than the total of the 640,000 Japanese soldiers and head were captured to Soviet Union in War of Liberation. Theirs 609,000 were Japanese and 30,000 were other nationalities. Soviet Union to handed over 12,318 prisoners of the Japanese soldiers to Mongolia in November, 1945. Calculating the actual cost of Japanese prisoner of war that were working in the Soviet Union and Mongolia. 61,855 of 609,448 Japanese prisoners died in the Soviet Union, or 10.14% and 1,612 of 12,318 Japanese prisoners died in Mongolia, or 13.08%.

ЗӨВЛӨЛТИЙН ХОЁР ЭРДЭМТНИЙ МОНГОЛЫН ТАЛААР БИЧСЭН НОМЫН ШҮҮМЖ

Ж.УРАНГУА

АНУ-ын Тагнуулын Төв Газрын Архив нууцлалын зэрэгтэй материалуудыг 25 жилийн дараа нууцын зэрэглэлээс гаргах асуудлыг авч үзэн, шийдвэр гаргадаг амуй. Одоогийн байдлаар нууцын зэрэглэлээс гарсан 930 мянган материал Интернетэд тавигдсан байна¹. Эдгээрээс хоёр баримтыг сонгон авч орчууллаа.

АНУ нь тэртээ 1950-иад оны үед Монголын талаар сонирхож байсны нэг илрэл бол тус орны талаар Зөвлөлтийн эрдэмтдийн бичсэн бүтээлийг Монголч эрдэмтнээр уншуулж, тэрхүү номын мэдээлэл хэр зэрэг үнэн бодитой болохыг нягтлуулж байжээ. Үүний нэг жишээ бол Монголын талаар ЗХУ-д 1950 болон 1948 онд хэвлэгдсэн “БНМАУ-шинэ ардчиллын улс. Түүхэн тойм” болон “БНМАУ-ын физик газарзүйн тодорхойлолт” гэсэн хоёр номд ЗХУ –аас Америкт дүрвэн очсон Оросын нэрт Монголч эрдэмтэн, хэл шинжээч Николас Поппе (1897-1991)-гоор 1953 онд АНУ-ын Тагнуулын Төв Газар шүүмж бичүүлжээ. Тэрхүү шүүмжийг толилуулж байна².

Тагнуулын Төв Газар Мэдээллийн тайлан³

Улс: БНМАУ

Сэдэв: Зөвлөлтийн “БНМАУ-шинэ ардчиллын улс. Түүхэн тойм”

“БНМАУ-ын физик газарзүйн тодорхойлолт” номын шүүмж

Хэвлэгдсэн он: 1950,1948

1. И.Златкины “БНМАУ-шинэ ардчиллын улс. Түүхэн тойм” номын редактор нь И.М.Майский. ЗХУ-ын “Шинжлэх ухаан . М-Л., 1950, 290 хуудас, 2 газрын зурагтай.
2. Шүүмжлэгчийн тайлбар: Энэ номын нэрнээс нь харахад сурталчилгааны

¹ Central Intelligence Agency. 2017 оны 1 сарын 17

² Орчуулгыг АНУ-ын Төрийн департаментын монгол хэлний багш, доктор М.Саруул-Эрдэнээр хянуулав- Ж.У.

³ ТТГ-ын ерөнхий тайлан. 1951 оны 12 сарын 1. Ангилал С. Баримтыг 1998 онд нууцын зэрэглэлээс гаргасан. 2016 оны 11 сарын 9-нд тус байгууллагын Цахим санд тавигдсан байна.

ном байна- ЗХУ-ын дагуул улсын товч түүх. Зохиогч нь шинжлэх ухааны хүрээлэлд танигдаагүй хүн. Хянан нягтлагч нь ЗХУ байгуулагдсан эхний жил Сибирийн “Центросоюз” хоршооллын Сибирийн салбарын төлөөлөн удирдах зөвлөлийн дарга байсан, Нэгдсэн вант улсад Зөвлөлтийн ШУА-ийн төлөөлөгчөөр хэдэн жилийн өмнө тавигдсан. Энэ ном олон нийтэд зориулагдсан байна.

3. Өмнөх үг /1-10-р хуудас/-нд 30 жилийн өмнө Монголд хүмүүс зөвхөн морь, тэмээн хөсгөөр л нүүдэг байсан бол одоо машин, төмөр замтайболсон гэх гэнэн зүйл бичжээ. Миний бодлоор энэ тал дээр Америкийг ч гэсэн ингэж хэлж болно- Америктч гэсэн морь унацгаадаг байсан, харин одоо 3 хүний нэг нь машинтай.
4. Удиртгал хэсэг /т.11-62/-т Чингийн эрхшээлд орсноос эхлээд 1911 оны Хятадын хувьсгал хүртэлх Монголын товч түүхийг бичжээ. Энэ бүлэгт ямар нэгэн шинэ мэдээлэл байхгүй, энд бичигдсэн зүйлд дан орос хэл дээрх номуудаас мэдээлэл аван бичжээ. Монгол болон хятад эх сурвалж нэгийг ч ашиглаагүй. Барууны эрдэмтдийн бүтээлийг ер ашиглаагүй (жишээ нь Ховартын боть “Монголчуудын түүх”, Баудены 2 боть “Монгол,Орос,Хятад”). 1917 оны хувьсгалын үед Монголдфеодалын нийгэм байсан. гэхВладимирцовын эргэлзээтэй онолыг зохиогч хэд хэдэн удаа дурджээ.Монголчуудыг манж нар хэт их дарангуйлж байсан мэтээр Златкин хэлбийлгэн бичжээ. Чингэхдээ тэрээр дан сөрөг үйл явдлуудыг тоочин, Манжийн эерэг нөлөө болон монголчуудын давуу эрхийн талаар огт дурдсангүй: Монголын тайж ноёд өөрийн эзэмшил хошуу нутгаа өөрсдөө мэдэн захирах эрх, шашин шүтлэгийн эрх чөлөө,хутагт хувилгаадад манж нараас өгсөн эрх ямба, Монголд хятадууд цагаачлан ирэхийг болон хятад хүнтэй ураг барилдахыг хориглосон г.м.
5. Эхний бүлэг /62-112/Автономийн үеийн Монголын үндэсний эрх чөлөөний тэмцэл (1911-1919), Монголын талаарх Хаант Оросын бодлого болон 1911 оны үйл явдал (Хятадын хувьсгал) зэргийн талаар бичжээ. Энэ бүлэг бусад хэсгүүдтэй харьцуулбал харьцангуй бага алдаатай, мөн гуйвуулга байхгүй байна.
6. Дараагийн бүлэгт “1921 оны хувьсгал болон Бүгд Найрамдах байгуулалт” /т.113-157/ Энэ бол цэвэр суртал ухуулга, зохиомол түүхийн түгээмэл жишээ. Энэ бүлэг ичгүүргүй худал болон жигшүүрт гажуудалтай. Златкин,

Монгол Ардын Намыг зөвхөн Сүхбаатар, Чойбалсан мэтээр бичжээ /122-р тал/. Гэтэл үнэндээ энэ намыг Зөвлөлтийн хил дээр орших Маймаачин /одоогийн Алтанбулаг/-нд Бодоо, Данзан, Жамсарано, Цэрэндорж, Тогтох зэрэг хүмүүс 1921 онд байгуулсан. Харин Сүхбаатар, Чойбалсан хоёр нам байгуулах үед тэнд байгаагүй.

7. Энэ нам 1922 онд зүүний радикал үзэл бодолтой нам байсан, үүнд намыг үүсгэн байгуулагчийн нэг Бодоо сэтгэл хангалуун байгаагүй. Үүнээс болж өөрийн фракцийг нам дотроо байгуулсан. Энэ бүлэгт Тогтох, Жаа лам, Чагдаржав гэх мэт хүмүүс байсан. Элбэгдорж Ринчино эд нарыг барьж хороосон. Буриад Элбэгдорж Ринчино Зөвлөлтийн иргэн, тэрбээр Петербургийн Их Сургуулийг төгсөгч. Монголд ирэхээсээ өмнө хувьсгалт социалист үзэлтэй байсан, МАН-д элсэн орсон бөгөөд тус намын улаан удирдагч-намын нарийн бичгийн дарга болсон. Хожим нь намаас гаргаж, Москва руу Сталины “дахин боловсруулалтанд” Дорно дахины ард түмний Коммунист Их сургуульд явуулсан. Түүнийг Троцкийг дэмжигч, зүүний бодлогоос ухарсан, ардын дайсан, японы хуучин тагнуул хэмээн 1937 онд баривчлан буудан хороожээ. Өмнө дурдсанчлан Бодоо болон түүний хамсаатан зэрэг барууны үзэлтнүүдийг буудан алсан. Тэднийг Златкин /147-р тал/ Эхлээд Хаант засгийнхожмоо Японы тагнуулууд хэмээн гүтгэжээ. Энэ бол гүтгэлэг гэдгийг бид тодорхой. ЗХУ-ын дагуул бүх оронд коммунист биш үзэлтэй хүмүүсийг ингэж гүтгэдэг, зарим хүнийг Англи, Америкийн тагнуул гэж буруутгасантай агаар адил юм.
8. Адал явдалт Жаа лам улаантнуудтай нийлснийхээ дараа тэдэнтэй тэмцсэн учир цаазаар авхуулсан. Златкины бичсэн дээр би өөрөө нэмж хэлье. Жаа ламын толгойг тасдан авч, утаж давслаад 1922 онд Ленинград руу явуулсан. ШУА-ийн Антроплогийн музейд 1923 онд тавьсан. 1922 онд Монголын Тагнуулын алба байгуулагдсан. Товч нэр ГВО. /Улсын Дотоодыг хамгаалах газар/
9. Монголын хувьсгалын баатар, партизаны удирдагч Сүхбаатар 1923 оны 2 сарын 19-нд учир битүүлэг байдлаар нас барсан. Златкин бичихдээ: “1940 онд /17 жилийн дараа/ Чойбалсан хэлэхдээ, Данзан /148-р тал/ Сүхбаатарт хор өгч хордуулсан, учир нь Данзан Японы болон Хаант Оросын талын тагнуул байсан гэжээ. Хамгийн гайхалтай нь Златкин Чойбалсаны хэлсэн энэ баримт 17 жилийн дараа гарч ирснийг уншигчдад огт тайлбарлаагүй

байна. Үнэндээ хэрэв энэ тийм байсан бол ийм мэдээг Сүхбаатарыг нас бармагц дэлгэх ёстой. Тиймээс энэ бол эвлүүлэг, худал зүйл. 1923 онд Монголын лам нарыг Сүхбаатарын эмчилгээнд буруу эм өгсөн хэмээн буруутгаж байсныг би санаж байна. Учир нь Сүхбаатар өөрөө ламын эмчилгээг таашаадаг хуучинсаг үзэлтэй хүн байсан, барууны эмчилгээг сонгоогүй юм.

10. Энэбүлэгт МАН-ын III их хурлын шийдвэрийн талаар бичжээ. Намын шинэ төлөвлөгөө болох Капиталист бус хөгжлийн зам: коммунист болон социалист \т.150\ хөгжлийн төлөвлөгөөг боловсруулсан. Нам өөрийгөө албан ёсоор Ардын гэсэн боловч коммунист нам байгаагүй, гэхдээ анхнаасаа Коминтерны гишүүн байсан.
11. Гуравдугаар бүлэг “Баруунтан болон зүүнтнийхнээс феодализм ба колонийн боолчлолыг дахин сэргээхийн эсрэг МАН-ын хийсэн тэмцэл 1924-1932” \т.130\ Энэ бүлгээс МАН нь Япон болон лам нарыг их аюултай хэмээн үздэг байсныг харж болно. Энэ хоёрыг нэг дор нэг ч удаа хамт дурдаагүй нь учиртай. Яагаад гэвэл хамгийн түүрүүнд 1924 онд шашныхны эсрэг дайралт эхэлсэн. Үүнд Златкин тайлбар олох ёстой байсан. Златкин хутагт хувилгаадыг Японы тагнуул байсан гэж харуулахыг оролдож тэднийг ардын болон засгийн дайсан болгон харуулсан. Тэрбээр лам нарыг Японы тагнуул гэж гүтгэсэн, энэ нь Зөвлөлтийн дагуул орнуудыг судалсан хүмүүст их танил нэр томьёо, гүтгэлэг юм. Румыны Ромын католик, Югославын кардинал, эсвэл Зүүн Германы протестант лам ч байна уу, бүгдийг нь гадны тагнуул (АНУ, Их Британи гэх мэт) хэмээн гүтгэдэг байсан.
12. Баруунтнууд нь 1924-1925 онд Намын жажин шугамаас хазайсан бодлого хэрэгжүүлж эхэлсэн хэмээх нь ийм учиртай. Боловсролын сайд Эрдэнэбатухан монгол оюутнуудыг Герман, Францад сургахаар явуулсан юм. Би Батуханыг сайн мэднэ. Түүнийг Зөвлөлт руу хөөж гаргасан, тэрбээр Ленинградын Дорно Дахины Хүрээлэнд надтай хамт ажиллаж байсан. Тэрбээр надад ингэж ярьж байв: Монгол оюутнуудыг Зөвлөлт руу бус, Европ руу явуулсан шалтгаан нь бол Зөвлөлтөд хоол, байрны нөхцөл муугийн улмаас болсон юм. Ленинградад сурч буй оюутнууд 6 долоо хоног болоход сүрьеэ тусаж байсан. Би үүнийг баталж чадна, анх гадаадад суралцуулахаар илгээсэн оюутнууд

болох 1922-1924 хооронд Ленинградад 4 монгол, нэг төвөд нас барсан. Эрдэнбатухан Ленинградад баривчлагдсан, 1937 онд хорих лагерь руу явуулсан, би түүнээс 1938 онд нууцаар явуулсан нэгэн захидлыг нь хүлээн авсан. Тэрбээр өөрийгөө үхтлээ турж эцсэн, тусална уу-гэсэн байсан боловч үнэндээ надад ямар боломж байгаагүй. Монголд гэр бүлийнхэн нь бас зовжбайсан. 1935-1936 онд Европ руу явуулсан бүх оюутнуудыг баривчилж, ихэнхийг нь устгасан. Тэдний нэг нь Мэргэн гүн Гомбожав юм. Тэр тайжийн хүүхэд, Францад алдарт Дорнодахин судлаач Паул Пеллиогийн удирдлага дор сурч байсан. Энэ бүхний талаар Златкин юу ч бичээгүй байна. Эдээрийг хэлэх нь миний бодлоор зөв, учир нь Монголд тэр үед юу болж байсныг хэлэх нь зөв.

13. 1924-1932 оны хооронд нугалаа явагдаж байсан. Златкин энэхүү нугалаа хэлмэгдүүлэлтийн талаар: 373 хошуунызахирагч (дүүргийн захирагч) нарын 79 нь л хуучин феодалууд байсан гэж дурьджээ. Тэрээр феодал гэдэг нь ямар хүнийг хэлж байгааг тайлбарлаагүй. Үнэндээ энэ феодал гэгч нь баривчлагдсан, устгагдсан, хорих лагерьт илгээгдсэн хүмүүс юм. 1928 онд амьд Буддагийн институцийг хаасан, хутагт хувилгаадыг дахин төрүүлэхийг үүрд хориглосон \т.187\ . Энэ нь юу болохыг Златкин огт хэлээгүй. Тэр зүгээр хориглосон эсвэл болиулсан л гэж бичсэн. Энэ бол Нью Йоркийн Бродвэй гудамжны замын хөдөлгөөнд буцаж эргэхийг хориглосон шиг юм огт биш. Үнэндээ амьд Буддагийн институцийн бүх лам нарыг шоронд хийсэн. Тэд нарыг ихэвчлэн Сибирийн Түрийханск дахь колонид явуулсан.
14. 1929 онд зүүнтнүүд нь намын бодлогоос ташаарсан зүйл хийсэн. Уншигч нар Златкины номын анзаарсан байх. Энэнь бүх зүйлийг хольсон зууш мэт: Японы тагнуул, хаант засгийн тагнуулууд, “баруунтан”, “зүүнтэн” гэх мэт өөр юу байгааг би мэдэхгүй, яг л Пандорагийн хайрцагны сюрприз мэт. Гэхдээ . Златкин зүүнтний нэрийг дурдаагүй ных сонин санагдаж магадгүй Үүний учир юу вэ? Хариулт нь их хялбар. Зүүнтний лидер гэж угаасаа байгаагүй, Оуен Латтиморын хэлдэг шиг Титочууд гэж ерөөс байгаагүй, тэрбээр мэдээллээ Златкин шиг нөхдөөс л авчээ. Үнэндээ зүүнтнүүд гээч нь Коминтерний засаглалын л үр дүн байсан юм. БНМАУ өөрөөр байх боломжгүй байсан, Зөвлөлтийн Коминтерны төлөөлөгчдийн үгээр л байхаас өөр зам байгаагүй. Коминтернын төлөөлөгчөөр эхлээд Рискулов, хожим Матвей Амагаев ирсэн. Амагаевыг 1931 онд Москвад

хөдөлмөрчдийн их сургуульд ажиллуулахаар явуулсан. Дараа нь 1934 эсвэл 1935 онд болов уу, Амагаевыг Лениградын Дорнодахины хэлний дэд сургуулийн захирал болгосноор тэр миний дарга болсон юм. Түүнийг 1937 онд Троцкийн талынх хэмээн буудан алсан.

15. Зүүнтнүүдийн хажуугаар лам нарын хөдөлгөөн идэвхэжсэн гэж Златкин бичжээ. Тэрээр Егүзэр, Дилов, Манзушир болон бусдын талаар дурджээ \т.198\ . Тэднийг Японы тагнуул гэсэн гүтгэлэг бол худлаа. Би Манзуширыг хувиараа мэднэ. Тэрбээр энэ ертөнцийн хэрэгт огт оролцдоггүй ганц амьд будда байсан. Үнэндээ, Златкин Зөвлөлтийн шашны эсрэг ажиллагааг зөвтгөх гэсэн хэрэг. Златкины Дэлэб гэж бичээд байгаа хүний жинхэнэ нэр нь бол Дилова Хутагт юм. Диловаг бас баривчилсан. Манзушир, Егүзэр зэрэг бусад \27\ амьд будда нарыг буудан хороосон. Дилов хутагтыг зугтахад түүнд найз нь тусалж, тэмээ өгч, тэрбээр цөлийг гатлан, Хятад руу явсан. Хэдэн жилийн дараа Оуэн Латтимортой тааралдсан бөгөөд Америк руу авч явсан. Тэрээр надад энэ бүх түүхээ ярьж өгсөн, Златкины бичсэн зүйл ичгүүргүй худал юм.
16. “Ламын бүлэглэл”, тагнуул зэрэг нь нийлэн янз бүрийн сөрөг бүлэглэлийг буй болгосон гэж Златкин бичжээ. Үнэндээ энэ бол тийм биш. Сөрөг бүлэглэл гээд байгаа нь хүн амын ихэнх хэсэг, намын гишүүд, Монголын улаан армийнхан хүртэл байсан бөгөөд засгийн газрын тэсэшгүй бодлогод эсэргүүцэл гаргасан хүмүүс юм. Энэ эсэргүүцлийг 1932 онд Зөвлөлтийн улаан арми онгоц болон танктай орж ирэн дарсан.
17. Мэдээжээр зүүнтнүүдийн алдааг Коминтерны буруу гэж хэлж чадахгүй байж. Гэвч хэн нэгнийг буруутгах хэрэгтэй байсан. Тиймээс Монголд “зүүнтний бүлэг” гэсэн үлгэр бий болгосон. Энэ засгийн газар Коминтерны үгэнд орохоос өөр арга зам байгаагүй, тэднийг хожим нь баривчлан шүүсэн. Засгийн газрын тэргүүн Гэндэн, ерөнхий сайд болон Гадаад хэргийн сайд Амар нарыг шүүж, японы тагнуул гэж гүтгэн цаазаар авсан, энэ үйл явдал 1936 онд болсон. Энэ үед Монгол гарцаагүй Зөвлөлтийн дагуул болсон, Засгийн газар нь сөнөж, зөвлөлтийн бүтээлүүд орж ирж, эрх барьсан.
18. Дөрөвдүгээр бүлэг “БНМАУ капиталист бус хөгжлийн замд” \т.206\ Үүнд, Златкин зүүнтнүүдийн ташаа бодлогыг үр дүнг засаж залруулсан талаар бичжээ.

19. Үлдсэн хуудаснууд нь Дэлхийн II дайны үйл явдлууд болон 1945 оны Японыг дарахад Монголын цэргийн оролцооны талаар өгүүлжээ.
20. Төгсгөлд нь би Златкины ном Монголын талаар их буруу төсөөлөл өгч байна. Харамсалтай нь үүнийг худал гэдгийг БНМАУ-д өөрөө байж, өөрөө бүхнийг харсан хүн л хэлж чадна. Энэ бол муу ном.¹

21. *И.Мурзаев “БНМАУ-ын физик газарзүйн тодорхойлолт” ЗХУ-ын ШУА, Газар зүйн хүрээлэн, Улсын хэвлэлийн газар. Москва 1948 он, 314 хуудас, их олон зураг болон газрын зурагтай (орос хэлээр)*
22. Шүүмжлэгчийн өчиг: Монголын, гэхдээ геологи, ургамал болон амьтан судлалын янз бүрийн судалгаа хийгдэж байсан боловч ерөнхий газар зүйн судалгаа хийгдээгүй. Тиймээс ЗХУ-аас гаднах Монголд холбогдох мэдээлэл олоход хэцүү. Британиар нэвтэрхий тольд Монголын талаарх ташаа мэдээлэл их бий. Мурзаевын ном бол чухал бүтээл, найдвартай мэдээлэлтэй, сайн бүтээл байна.
23. Эхний бүлэг “Газар зүйн ерөнхий байдал”. Эндээс бид нутаг дэвсгэрийн хэмжээ, газар зүйн янз бүрийн байршил, хил хязгаарын дүрслэл өгчээ \т.7-10\ . Үүнийг хэлэх ёстой болов уу? Монгол бол газарзүйн үүднээс их сонирхолтой газар. Дэлхий дээрх агаарын хамгийн өндөр даралттай газруудын нэг, хамгийн өмнө зүйгийн хөрсний хөлдөлттэй газар, хамгийн хойд зүгийн хүйтэн цөлтэй газар, эх газрын эрс тэс уур амьсгалтай газар юм. Энэ бүлгийн дараа нь ерөнхий тодорхойлолт өгчээ. Энэ нь Монголын талаарх мэдлэггүй хүн бол чухал, гэвч Казакевичийн “Орчин үеийн Монголын топографи” \орос дээр , Ленинград 1934\
24. Товчхон: “Засаг захиргаа болон хүн ам, эдийн засгийн мэдээлэл” \18-36\ Монголын талаар бага мэдлэгтэй хүнд л сонирхолтой мэдээлэл болно. Энэ мэдээ хэсэгчилсэн бөгөөд товч байна. Харин дараагийн “Газар зүйн судлалын түүх” илүү их сонирхолтой харагдаж байна \36-58\ . Энэ бүлэгт Монголоор XIII зуунаас эхлэн аялсан хүмүүсийн бичсэн мэдээлэл \лам Пано Карпини, Рубрук болон худалдаачин Марко Поло\ байна. Зарим хүмүүсийн тухай оруулаагүй байна. Тухайлбал, Чингисийн үеийн лам Чан чун бомбо. Түүний талаар Палладий болон Бритчнейдер нар бичсэн

¹ 1951 оны “Вопросы истории” сэтгүүлийн № 6 -д Ф. Зөөвлөлтийн судлаач Цаплин, И. Юрьев нар шүүмж хэвлэгдсэн бөгөөд түүнд Монгол улс Ардын засаг ялсанаас хойших 30 жилд ЗХУ-ын тусламжийн ачаар хөгжлийн ямар түвшинд хүрсэнг И.Я. Златкины тод томруун харуулж өгсөн, үнэ цэнэ бүхий сайн бүтээл болсон хэмээн бичжээ.

- байдаг. Шинэ үед хийгдсэн ажлууд нилээд оржээ. Гэхдээ Бадлий “Орос-Монгол-Хятад” номонд чухал мэдээлэл байдаг боловч үүнийг оруулаагүй байна. Шашин номлогч изуитуудыг нэг л удаа дурджээ. Чингэхдээ “Орос судлаачидтай харьцуулбал маш бага судалгаа хийсэн”\т.45\ гэжээ. Зөвлөлт засгаар буруутгагдсан судлаачдын бүтээлийг оруулаагүй байна. Жишээ нь, буриад козак Цогт Бадамжапов Козловын хамт Хар хотын балгасыг олсон, Монголын Улаанбаатарын Шинжлэх ухааны хүрээлэнд ажиллаж байсан газарзүйч А.Д.Симуков нарыг. Энэ хоёрыг Зөвлөлтийн нууц цагдаа баривчлан 1937 онд хороосон.
25. “Газар дээр бүтцийн тодорхойлолт” \т.58\ Энэ бүлэг их чухал бөгөөд үүнээс Монголын далайн түвшинээс дээших газар нутгийн тухай ихийг мэдэж болно. Хамгийн нам газар бол Монголын зүйн хойд дахь Хөхий нуур \532 м.\, хамгийн өндөр цэг нь Алтай таван Богд\4653 м.\, дундаж өндөрлөг 1580, Улаанбаатар нийслэл нь 1297 метр \т.59\.
- Энэ бүлэгт газарзүйн талаарх мэдээлэл байна, гэхдээ хөрсний чанар болон байгалын баялгийн талаар дурдаагүй байна. Бас үүнийг нэмье: цөлний хэмжээг хэтрүүлэн бичжээ. Ер нь бол Монголын цөлийг хүмүүс хэтрүүлж хэлдэг. Мурзаев Монголын нийт талбайн 1 сая 531 мянган кв.км-ыг 29916 кв.км \1.96 % элс\
26. 78-р талд газар нутгийн үүслийн талаар их сонирхолтой судалгаа үзэж болно. Зохиогч хэлэхдээ:
- А. Монголын эх газрын цаг агаарын чанар нь палеозойк эрин үеэс эхлэн мезозойк эрин хүртэл үргэлжилсэн,
 - Б. Мезойкийн үед газар нутгийн гол болон нуурын тогтоц буй болсон,
 - В. Уул нурууд гарч ирсэн \Гертарын төгсгөл, Квартарын эхлэл\ Монголын цөл нь их эртний, тийм учраас их хуурай\.
- Хуурай цаг уур нь их нурууд үүссэнээс болсон. Далай халуун чиглэг агаарыг хаасан.
27. Цаг агаар, температур, хур борооны талаарх мэдээлэл их сонин байна. Дараачийн бүлэг нь гол болон нууруудын талаар \т.115-125\ болон газар зүйн бүсүүдийн талаар. Эдгээр бүсүүд байна гэжээ:
- А. Уул, ой мод болон тал газрын бүс
 - Б. Өндөр тал хээрийн бүс
 - В. Тал болон тал цөл
 - Г. Цөл

28. Эдгээр бүсүүдийн их сайн дүрсэлж, ан амьтад болон ургамлын талаар дэлгэрэнгүй бичжээ.
29. Монголын физик газарзүйг тайлбарлажээ: Алтайн уулс, Их нуурын хотгорууд, Хангай болон Хэнтий нурууны уулс, өндөрлөг тал нутаг болон говийг.
30. Ном зүй болон Нэрийн хэлхээс номын төгсгөлд оржээ.
31. Эцэст нь, би энэ их найдвартай номыг хүмүүсийг уншихыг зөвлөж байна. Миний бодлоор энэ номыг англи руу орчуулах нь зүйтэй байх.

Abstract: The CIA archive will release confidential information after 25 years if the said documents are deemed no longer necessary to be confidential. As of today, there are 930 thousand materials are put on the internet. We have selected two texts and translated it. In 1950, two Soviet books about Mongolia was reviewed by a Mongolist scientist. Nicolas Poppe (1897-1991) reviewed these two books and gave his criticism to the CIA in 1953. He was a Russian Mongolist scientist who took refuge in the USA. These two books are “The Mongolian People’s Republic -- a country new democracy -- an outline of history.” and “The Mongolian People’s Republic, a physical geographic description.” published in USSR in 1950 and 1948 respectively. Therefore, these two criticisms are presented.